

## БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН 2008 ОНЫ НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА


2009.01.31

Улаанбаатар хот

### НЭГ. ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ТАЛААР

Хорооны тогтоолоор 2008 онд 10 ХХК-нд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 15 ББСБ ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор нийт 132 ББСБ-ын жилийн эцсийн санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдлаа.

ББСБ-ын тоон үзүүлэлтийг өмнөх онуудтай харьцуулахад дараах байдалтай байна.



ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээг эрхэлж буйгаар нь ангилахад дараах байдалтай байна. Үүнд:

№	Үйл ажиллагааны төрөл	Тоо	№	Үйл ажиллагааны төрөл	Тоо
1	Зээл	130	6	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	9
2	Факторингийн үйлчилгээ	7	7	Гадаад валютын арилжаа	55
3	Санхүүгийн түрээс	7	8	Итгэлцлийн үйлчилгээ	14
4	Төлбөрийн баталгаа гаргах	5	9	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	3
5	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	10	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	8

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан ч үйл ажиллагаа явуулж эхлээгүй болон 2008 оны эцсээр санхүүгийн тайлангаа ирүүлээгүй 6 ББСБ ХХК-ийг өмнөх улирлын байдлаар болон эхлэлтийн тайлангаар санхүүгийн нэгтгэлд хамруулсан нь нийт ББСБ-уудын 4.4 хувийг эзэлж байна.

Тайлант онд Улаанбаатар хот болон орон нутаг дахь ББСБ-ын нийт салбар, нэгжийн тоо 42, нийт хувь нийлүүлэгчдийн тоо 445, нийт ажиллагсдын тоо 657 гаруйд хүрсэн ба давхардсан тоогоор 120.0 мянга гаруй харилцагчдад /үүнээс мөнгөн гуйвуулгын үйлчилгээнд 74.9 мянган харилцагчдад/ санхүүгийн үйлчилгээг үзүүлжээ.

Судалгаанаас үзэхэд ББСБ-уудын олгож буй зээлийн хүүгийн түвшин дундажаар 3.0-4.5 хувь, бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрт төлж буй хүүгийн түвшин дундажаар 1.0-2.5 хувь байна.

Хорооны 2007 оны 122 дугаар тогтоолоор зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоосон журмын дагуу нийт 125 ББСБ 2008 оны зохицуулалтын үйлчилгээний хөлс 112.1 сая төгрөг төлсөн байна

### Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-үүдэн талаар

Гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 11 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.3 хувийг, тэдгээрийн нийт актив 17,408.6 сая төгрөгт хүрсэн нь ББСБ-ын нийт активын 22.2 хувийг, нийт олгосон зээл, түүнтэй адилтган тооцох актив 8,932.0 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 19.2 хувийг тус тус эзэлж байна.

Харьяаллаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1 /Зөн сан Монгол/, Япон улсын хөрөнгө оруулалттай 4 /Марико, Сар шинэ интернейшл, Цагаан ажнай, Жи Си Ай Пу/, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс, БНХАУ, БНСУ, Итали, Казахстан, АНУ зэрэг 100 хувийн ба хамтарсан хөрөнгө оруулалттай 6 /Ийт Уэст факторин, Футур эволюшн, Би И Ай, Мөнгөн бүрэн, Халык астана дорнод, Финанс энд девелопмент оф тайнинг/ ББСБ үйл ажиллагаа явуулж байна.

### Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-үүдэн талаар

Орон нутагт 23 ББСБ ХХК үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-уудын 17.4 хувийг, тэдгээрийн нийт актив 2,076.8 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын активын 2.6 хувийг, нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 1,649.7 сая төгрөг байгаа нь нийт ББСБ-уудын олгосон зээл, түүнтэй адилтган тооцох активын 3.6 хувийг тус тус эзэлж байна.



## ХОЕР. НИЙТ АКТИВ

2.1 Активын өөрчлөлт болон чанарын талаар

Нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:


ХӨРӨНГӨ		2008.12.31	Хувь	2007.12.31	Хувь	/мянган төгрөгөөр/	
А	Эргэлтийн хөрөнгө	74,419,446.9	94.8%	61,555,559.7	92.6%	12,863,887.2	2.2%
1	Мөнгөн хөрөнгө	20,050,521.1	25.5%	17,907,111.2	27.0%	2,143,409.9	-1.5%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	2,119,547.5	2.7%	4,331,695.7	6.5%	-2,212,148.2	-3.8%
3	Нийт зээл	46,446,274.0	59.1%	35,394,917.3	53.3%	11,051,356.7	5.8%
	Зээл /цэврээр/	44,474,232.3	56.6%	34,141,791.2	51.4%	10,332,441.1	5.2%
	(Зээлийн эрсдлийн сан)	1,972,041.7	2.5%	1,253,126.1	1.9%	718,915.6	0.6%
4	Санхүүгийн түрээсийн тооцооны авлага /цэврээр/	292.9	0.0%	7,122.60	0.0%	-6,829.7	0.0%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	672.6	0.0%	0.0	0.0%	672.6	0.0%
5	Факторингийн тооцооны авлага /цэврээр/	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	350.0	0.0%	350.0	0.0%	0.0	0.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	72,072.1	0.1%	0.0	0.0%	72,072.1	0.1%
	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө /цэврээр/	33,662.4	0.0%	316,636.8	0.5%	-282,974.4	-0.5%
	Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	56,080.6	0.1%	435,106.9	0.7%	-379,026.3	-0.6%
	(ӨБҮХХ-ийн болзошгүй эрсдлийн сан)	22,418.1	0.0%	118,470.1	0.2%	-96,052.0	-0.2%
	Өмчлөх бусад хөрөнгө	38,409.7	0.0%	0.0	0.0%	38,409.7	0.0%
7	Бусад хөрөнгө	7,702,780.9	9.8%	6,561,224.3	9.9%	1,141,556.6	-0.1%
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1,303,447.6	1.7%	840,505.6	1.3%	462,942.0	0.4%
8	Авлага /цэврээр/	2,598,649.5	3.3%	1,381,667.8	2.1%	1,216,981.7	1.2%
	(Авлагын эрсдлийн сан)	21,834.2	0.0%	11,717.5	0.0%	10,116.7	0.0%
	Бусад актив	3,800,683.8	4.8%	4,327,333.4	6.5%	-526,649.6	-1.7%
Б	Эргэлтийн бус хөрөнгө	4,111,293.3	5.2%	4,570,718.5	6.9%	-459,425.2	-1.7%
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,111,293.3	5.2%	4,570,718.5	6.9%	-459,425.2	-1.7%
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,068,242.0	1.4%	884,021.2	1.3%	184,220.8	0.1%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>78,530,740.2</b>	<b>100.0%</b>	<b>66,442,914.9</b>	<b>100.0%</b>	<b>12,087,825.3</b>	<b>0.0%</b>

Нийт актив эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотойгоор өмнөх оны мөн үеэс 18.2 хувь буюу 12,087.8 сая төгрөгөөр өсч, нийт активын бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна.

Тухайлбал, хүүгийн орлого авчирдаг актив болох зээлийн өрийн үлдэгдэл 11,051.4 сая төгрөгөөр нэмэгдсэнээр нийт активт эзлэх хувийн жин 53.3-59.1 хувь болж өссөн нь хүүгийн орлого авчирдаг активын өсөлтийн хурдац нь нийт активын өсөлтийн хурдацаас их байгаатай холбоотой.


Түүнчлэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2,143.4 сая төгрөгөөр өссөн ч нийт активт эзлэх хувийн жин 27.0-25.5 хувь болж буурчээ.

Харин богино хугацаат хөрөнгө оруулалт, эргэлтийн бус хөрөнгө, бусад активын үлдэгдэл болон тэдгээрийн нийт активт эзлэх хувийн жин тус тус буурсан үзүүлэлттэй байна.



**ББСБ-уудын нийт актив 2008 оны эцсээр 78,530.7 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын /банкны салбарын нийт актив 3,630,158.4 сая төгрөг/ 2.2 хувьтай тэнцэж байгаа ба активын өгөөж 6.1 /ROA/ хувь байна.**

Нийт ББСБ-уудыг нийт активын хэмжээгээр ангилахад дараах байдалтай байна.



**2.2 Зээлийн үйл ажиллагаа болон чанарын талаар**

ББСБ-уудын нийт эх үүсвэр нэмэгдсэнээр зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 31.2 хувиар өсч 46,446.3 сая төгрөгт хүрсэн нь нийт активын 59.1 хувийг эзэлж байгаа ч чөлөөт эх үүсвэр буюу мөнгөн хөрөнгөд нийт активын 25.5 хувь байршиж байгааг анхаарах нь зүйтэй байна.



**Нийт олгосон зээлийн өрийн үлдэгдэл 46,530.7 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт олгосон зээлийн өрийн үлдэгдлийн /банкны салбарын нийт зээл 2,715,007.5 сая төгрөг/ 1.7 хувьтай тэнцэж байна.**

Хэвийн зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 8,877.8 сая төгрөг буюу 27.2 хувиар өссөн ч нийт зээлийн багцад эзлэх хувийн жин 92.3-89.4 хувь болж буурсан байна. Энэ нь нийт зээлийн өрийн үлдэгдлийн өсөлтийн хурдацаас /31.2 хувь/ бага байгаатай холбоотой юм. Харин хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл өссөн үзүүлэлттэй байгаа нь санхүүгийн хямралтай холбоотойгоор зээлийн

эргэн төлөлт буурч, зээлийн чанар муудах хандлагатай байгааг харуулж байна. Үүний дүнд зээлийн эрсдэлийн сан өмнөх оны мөн үеэс 718.9 сая төгрөгөөр нэмэгдсэнээр ББСБ-уудын ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.

/мянган төгрөгөөр/

	Зээлийн ангилал	2007.12.31			2008.12.31			өөрчлөлт Мөнгөн дүн
		Мөнгөн дүн	Хувь		Мөнгөн дүн	Хувь		
			Зээлийн багцад	Нийт активт		Зээлийн багцад	Нийт активт	
1	<b>Хэвийн</b>	32,655,206.72	92.3	49.1	41,533,022.63	89.4	52.9	8,877,815.91
2	<b>Хугацаа хэтэрсэн</b>	1,194,371.50	3.4	1.8	2,270,967.19	4.9	2.9	1,076,595.69
3	<b>Чанаргүй Үүнээс:</b>	1,545,339.06	4.4	2.3	2,642,284.16	5.7	3.4	1,096,945.10
	а/ Хэвийн	325,873.92	0.9	0.5	1,031,142.33	2.2	1.3	705,268.41
	б/ Эргэлзээтэй	537,922.94	1.5	0.8	269,488.82	0.6	0.3	-268,434.12
	в/ Муу	681,542.20	1.9	1.0	1,341,653.01	2.9	1.7	660,110.81
	<b>НИЙТ</b>	<b>35,394,917.28</b>	<b>100</b>	<b>53.3</b>	<b>46,446,273.98</b>	<b>100</b>	<b>59,1</b>	<b>11,051,356.70</b>



## ГУРАВ. НИЙТ ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЦИЙН ТАЛААР

### 3.1 Нийт эх үүсвэрийн өөрчлөлтийн талаар

Тайлант оны нийт эх үүсвэрийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна.

/мянган

төгрөгөөр/



ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2008.12.31	Хувь	2007.12.31	Хувь	өөрчлөлт	Хувь
<b>А Өр төлбөр</b>	<b>16,462,326.8</b>	<b>21.0%</b>	<b>2,557,890.8</b>	<b>3.8%</b>	<b>13,904,436.0</b>	<b>17.2%</b>
1 Итгэлцлийн үйлчилгээний өглөг	2,846,290.3	3.6%	2,557,890.80	3.80%	288,399.5	-0.2%
2 Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	9,646,306.6	12.3%	4,631,680.7	7.0%	5,014,625.9	5.3%
3 Бусад эх үүсвэр	1,215,690.6	1.5%	1,303,417.3	1.9%	-87,726.7	-0.4%
Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	4,584.9	0.0%	19,045.70	0.00%	-14,460.8	0.0%
Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	1,211,105.6	1.5%	1,284,371.60	1.90%	-73,266.0	-0.4%
4 ББСБ-аас гаргасан өрийн бичиг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
5 Төслийн зээлийн санхүүжилт	2,754,039.3	3.5%	3,551,638.90	5.30%	-797,599.6	-1.8%
<b>Бусад өр төлбөр</b>	<b>7,050,758.0</b>	<b>9.0%</b>	<b>6,324,833.10</b>	<b>9.50%</b>	<b>725,924.9</b>	<b>-0.5%</b>
6 Хуримтлуулж тооцсон хүүгийн	263,575.4	0.3%	294,705.10	0.40%	-31,129.7	-0.1%

	өглөг						
7	Бусад пассив	6,787,182.6	8.6%	6,030,127.90	9.10%	757,054.7	-0.5%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
<b>Нийт өр төлбөр</b>		<b>23,513,084.9</b>	<b>29.9%</b>	<b>18,369,460.80</b>	<b>27.60%</b>	<b>5,143,624.1</b>	<b>2.3%</b>
<b>Б</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>	<b>55,017,655.3</b>	<b>70.1%</b>	<b>48,073,454.10</b>	<b>72.40%</b>	<b>6,944,201.2</b>	<b>-2.3%</b>
9	Хувьцаат капитал	46,737,684.5	59.5%	41,774,709.5	62.9%	4,962,975.0	-3.4%
10	Бусад өмч	582,939.9	0.7%	702,281.20	1.00%	-119,341.3	-0.3%
11	Сангууд	1,108,233.7	1.4%	1,106,918.6	1.6%	1,315.1	-0.2%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	6,176,033.8	7.9%	4,035,530.8	6.1%	2,140,503.0	1.8%
13	Хоёрдогч өглөг	412,763.4	0.5%	454,013.80	0.70%	-41,250.4	-0.2%
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>		<b>78,530,740.2</b>	<b>100.0%</b>	<b>66,442,914.90</b>	<b>100.00%</b>	<b>12,087,825.3</b>	<b>0.0%</b>

Тайлант хугацаанд бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө болох банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ 2.1 дахин буюу 5,014.6 сая төгрөгөөр, хувьцаат капитал буюу дүрмийн сангийн хэмжээ 11.9 хувь буюу 4,963.0 сая төгрөгөөр, хуримтлагдсан ашиг 53.1 хувь буюу 2,140.5 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээр нийт эх үүсвэр өмнөх оны мөн үеэс 18.2 хувиар өсчээ.

Нийт эх үүсвэрийн бүтцэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал, эзэмшигчдийн өмч буюу өөрийн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн ч өөрийн хөрөнгийн өсөлтийн хурдац нь нийт эх үүсвэрийн өсөлтийн хурдацаас бага байснаас нийт эх үүсвэрт эзлэх хувийн жин нь 72.4-70.1 хувь болж буурчээ. Энэ нь ББСБ-ууд бусдаас санхүүгийн эх үүсвэр их хэмжээгээр татан төвлөрүүлж байгаатай холбоотой.


Нийт эх үүсвэрийн 70.1 хувийг өөрийн хөрөнгөөр бүрдүүлсэн нь бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх явц нь зохистой түвшинд байгааг харуулж байна. Гэхдээ бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх сувгийг олон болгох, санхүүгийн зах зээл дээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах сонирхлыг дэмжих хэрэгтэй байгааг анхаарч үзэх хэрэгтэй байна.



### 3.2 Өөрийн хөрөнгийн талаар

ББСБ-ууд үйл ажиллагааныхаа цар хүрээг өргөжүүлэх зорилгоор дүрмийн сангаа нэмэгдүүлсэн, хуримтлагдсан ашиг өсч байгаа зэргээс шалтгаалж өөрийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 14.4 хувиар буюу 6,944.2 сая төгрөгөөр өссөн байна.

Цаашид ББСБ-уудын чанарын өсөлтийг тууштай дэмжиж, өөрийн хөрөнгийн хэмжээ болон санхүүгийн чадавхийг нь дээшлүүлэх бодлогыг баримтлан Хорооны 2008 оны 169 дүгээр тогтоолоор ББСБ-ын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор нэмэгдсэнээр ББСБ-уудын санхүүгийн эх үүсвэр өсч, төлбөрийн чадвар сайжрах болно.



Нийт өөрийн хөрөнгө 55,017.7 сая төгрөг байгаа нь банкны салбарын нийт өөрийн хөрөнгийн /банкны салбарын өөрийн хөрөнгө 342,080.5 сая төгрөг/ 16.1 хувьтай тэнцэж байгаа ба өөрийн хөрөнгийн өгөөж 8.3 /ROE/ хувь байна.

## **ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

### 4.1 Орлогын бүтцийн талаар

Нийт эх үүсвэр нэмэгдэж, олгосон зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 31.2 хувиар өссөнөөр нийт орлого өмнөх оны мөн үеэс /өмнөх оны мөн үед нийт орлого 13,812.4 сая төгрөг/ 36.8 хувь буюу 5,084.6 сая төгрөгөөр өсч 18,897.0 сая төгрөгт хүрсэн ба нийт орлогын гол эх үүсвэр нь зээлийн хүүгийн орлого болсоор байна.


Нийт орлогын бүтэц дараах байдалтай байна. Үүнд:



Тайлант онд зээлийн хүүгийн орлого өмнөх оны мөн үеэс 8,304.9-11,357.0 сая төгрөг болж, 36.8 хувиар өссөн ч нийт орлогын өсөлтийн хурдацтай адил байгаагаас нийт орлогод эзлэх хувийн жинд өөрчлөлт ороогүй, тогтвортой байна. /өмнөх оны мөн үед зээлийн хүүгийн орлогын нийт орлогод эзлэх хувь 60.2 хувь/

**4.2 Зардлын бүтцийн талаар**

Нийт зардал өмнөх оны мөн үеэс /өмнөх оны мөн үед нийт зардал 11,110.7 сая төгрөг/ 34.6 хувь буюу 3,848.8 сая төгрөгөөр өсч 14,959.6 сая төгрөгт хүрчээ.



Зардлын өсөлтийн шалтгаан нь нэгдүгээрт, банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн болон итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ нэмэгдсэн зэрэг объектив хүчин зүйлээс шалтгаалж хүүгийн зардал өссөн, хоёрдугаарт, гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс шалтгаалж ханшийн тэгшитгэл, арилжааны алдагдал нэмэгдсэн, гуравдугаарт, боловсон хүчний холбогдолтой зардал нэмэгдсэн, дөрөвдүгээрт, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн хэмжээ нэмэгдэж, зээлийн чанар муудаж байгаагаас эрсдлийн зардал өссөн зэрэгтэй тус тус холбоотой байна.

**4.3 Ашигийн талаар**

Тайлант хугацаан дахь татварын дараах цэвэр ашиг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад /өмнөх оны мөн үеийн цэвэр ашиг 2,701.7 сая төгрөг/ 45.7 хувиар буюу 1,235.8 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.




Энэ нь ББСБ-уудын үйл ажиллагааны цар хүрээ өсч, өөрийн хөрөнгийн хэмжээ болон бусдаас татан төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэр нэмэгдсэнээр санхүүгийн зуучлалын хүрээ өргөжсөнтэй холбоотойгоор нийт орлого өссөн, өөрөөр хэлбэл, нийт орлогын өсөлтийн хурдац нийт зардлын өсөлтийн хурдацаас их байгааг харуулж байна.

Тайлант хугацаанд тодорхой хэмжээгээр ашигтай ажилласан 107 ББСБ байгаа нь нийт ББСБ-ын 81.1 хувийг эзэлж байгаа ба тэдгээрийн ашиг 6.0 мянган төгрөгөөс 497.3 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа ба ашигтай ажилласан ББСБ-уудын арифметик дундаж ашиг 45.0 сая төгрөг байна.

Харин 22 ББСБ буюу нийт ББСБ-уудын 16.7 хувь нь 45.3 мянган төгрөгөөс 506.0 сая төгрөг хүртэл алдагдалтай ажилласан ба алдагдалтай ажиллаж байгаа зарим шалтгааныг нь тодруулж авч үзвэл, эрхэлж буй үйл ажиллагааны онцлог болон үйл ажиллагааны зардал өндөр, зээлийн чанар муудсанаар эрсдэлийн зардал өсч байгаа, үйл ажиллагаа жигдрээгүй зэргээс шалтгаалжээ.

ББСБ-уудын орлого, зардал болон нийт ашиг, алдагдлын тоон үзүүлэлтүүдийг он дарааллаар харуулахад дараах байдалтай байна.

/мянган төгрөгөөр/



### ТАВ. ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

ББСБ-ын нэгтгэлийн хувьд Хорооны 2008 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 191 тоот тогтоолоор батлагдсан □Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам□-аар тогтоосон үзүүлэлтүүд дараах байдалтай байна.

- нийт өөрийн хөрөнгө **55,017.7** сая төгрөг, эрсдлээр жигнэсэн актив **57,758.7** сая төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд **94.03** хувь, өөрийн хөрөнгийн хувьд **96.53** хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд **69.16** хувь,

- түргэн борлогдох актив **21,722.1** сая төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө **12,029.5** сая төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа **180.57** хувь,

- Гадаад валютаар олгосон зээлийн өрийн үлдэгдэл, кассат байгаа бэлэн валют, банкин дахь валютын харилцах дансан дахь үлдэгдэл нийт **11,670.3** сая төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө **6,343.0** сая төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдлийн зохисой харьцаа нь **9.68** хувь байгаа нь тус тус үзүүлэлтийг хангасан байна.

Харин эрсдэлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 459/207 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу **2,115.2** сая төгрөгөөр байгуулахаас **97.9** сая төгрөгөөр дугуу байгуулсан.

### **ЗУРГАА. ДҮГНЭЛТ**

ББСБ-уудын активын чанар салбарын хэмжээгээр харьцангуй сайн, хүүгийн орлого авчирдаг актив нийт активын 59.1 хувийг эзэлж байгаа, санхүү, төлбөрийн чадварын гол гол үзүүлэлтүүд эерэг байгаа ч тэдгээрийн санхүүгийн зуучлалд гүйцэтгэж байгаа үүрэг хязгаарлагдмал, банктай харьцуулахад өрсөлдөх чадвар сул хэвээр байна. Энэ нь санхүүгийн эх үүсвэр хязгаарлагдмал, хүрэлцээ бага байгаатай холбоотой байна.

ББСБ-ууд бусдаас санхүүгийн эх үүсвэр татан төвлөрүүлэх замаар үйл ажиллагаагаа өргөжүүлэхийн тулд банк, санхүүгийн байгууллагаас зээл авах, төсөлд хамрагдах, итгэлцлийн үйлчилгээ эрхлэх сонирхол нэмэгдэж байгаагаас нийт эх үүсвэрийн хэмжээ цаашид өсөх хандлагатай нь ажиглагдаж байна.

Иймээс ББСБ-уудын эх үүсвэрийг нэмэгдүүлэхийг дэмжих зорилгоор Засгийн газар хоорондын болон олон улсын байгууллагын шугамаар хэрэгжүүлэх төслийн хүрээнд олгох бөөний зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх, энэхүү зээлийг ББСБ-уудаар дамжуулан олгохыг Хорооноос тууштай дэмжих нь зүйтэй.

### **БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР**